



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2013 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/380

Улаанбаатар хот

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий нийслэлийн Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дэд зөвлөлийг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Дэд зөвлөлийн дарга Т.Бат-Эрдэнэд даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Салбар зөвлөл байгуулах тухай" Засаг даргын 2009 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 186 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ

111020001501

Нийслэлийн Засаг даргын 2013 оны
04 дүгээр сарын 11-ны өдрийн
А/380 дугаар захирамжийн хавсралт

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН
САНААЧЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙСЛЭЛИЙН
ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дэд зөвлөлийн дарга	Т.Бат-Эрдэнэ	Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд	Г.Болормаа	Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газрын дарга
	М.Дондогдорж	Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэлийн асуудал хариуцсан орлогч дарга
	Ц.Ишжамц	Нийслэлийн Татварын газрын Эрсдлийн удирдлага, мэдээллийн хэлтсийн дарга
	Ц.Батсайхан	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, аялал жуулчлал, геологи уул уурхайн техникийн улсын байцаагч
	Х.Болдбаатар З.Норжинлхам	Налайх дүүргийн Засаг дарга Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын эдийн засагч
	М.Отгонбаяр Э.Амарсайхан Н.Наранцэцэг Д.Ганболд	“Багануур” ХК-ний захирал “Сэрүүн сэлбэ” ХХК-ний захирал “Байгаль эхийн аврал сан” ТББ-ын тэргүүн Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн тэргүүн
	Ц.Эрдэнэбаатар	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны орлогч захирал
Нарийн бичгийн дарга	Ж.Содцэцэг	Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн